



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг:

tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг:

erdenechimegd@audit.gov.mn

Аудитор Н.Гэрэлмаа

Утас: 99782918 Цахим хаяг: gerelmaan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-12
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ТУНГАЛАГ ТАНАА**

2023.02.15

№

4

танай

-ны №

-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын онцолсон хэсэг

Статистикийн тухай хуулийн дагуу 5 жилд тутамд зохион байгуулагддаг Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явагдсан. Уг тооллогын ажлыг зохион байгуулахтай холбоотойгоор Үндэсний статистикийн хорооноос 59.0 сая төгрөгийн санхүүжилтийг хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо нь ХБНГУ-ын Цаг уурын нөлөөллийн судалгааны институт (PIK Берлин)-тэй гэрээ байгуулж "Монгол Улсын цаг уурын өөрчлөлтөд дасан зохицоход өрхөд дэмжлэг үзүүлэх" өрхийн панел судалгааг 2020-2022 онд зохион байгуулахаар мэдээлэл цуглуулалтын ажил 2020 оны 5 дугаар сараас эхлэн тус онд дууссан байна.

Аудитын гол асуудал

Үндэсний статистикийн хорооноос сар бүр авдаг өрхийн нийгэм эдийн засгийн болон ажиллах хүчний судалгааны мэдээлэл цуглуулалтад ашиглах зорилгоор 1 автомашин, хэлтсийн албан хаагчдад дутагдалтай байсан компьютер техник хэрэгслийг нийлүүлсэн.

0702000020

Бусад асуудлын хэсэг

Тус хэлтэс нь тайлант онд 2 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 96 хувьтай дүгнүүлсэн байна.

Үндэсний статистикийн хорооны жилийн эцсийн үнэлгээ гарах хугацаа болоогүй бөгөөд 3-р улирлын байдлаар аймаг нийслэлийн статистикийн хэлтсийн ажлыг 15 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд 7-р байрт үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)


	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,990.54	1,281.30
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	33,390.66	127,713.90
	Нийт хөрөнгийн дүн	35,381.20	128,995.20
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	35,381.20	128,995.20
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	35,381.20	128,995.20
	Үйл ажиллагааны орлогын дүн	318,735.58	469,834.19
	Үйл ажиллагааны зардлын дүн	320,251.63	376,220.19
	Үйл ажиллагааны үр дүн	(1,516.05)	93,614.00
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(1,516.05)	93,614.00
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	35,381.20	35,381.20
	Тайлант оны үр дүн	-	93,614.00
	Эцсийн үлдэгдэл	35,381.20	128,995.20
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	308,074.38	360,134.20
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	308,074.38	360,134.20
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	103,748.07	108,435.2
	Урсгал зардал	103,748.07	108,435.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	103,748.07	108,435.2
	Улсын төсвөөс санхүүжих	103,748.07	108,435.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

- ✓ Аудитаар нийт 3.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 заалт албан шаардлага хүргүүлсэн.

Албан шаардлага

- ✓ Бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг өмнөх оны зарцуулалттай харьцуулж үзэхэд хэмнэн ажиллаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон



холбогдох бусад зардлыг хэмнэх;" 15.2.4-т "бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх" заасныг зөрчсөн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Тайлант онд тендерт шалгараагүй аж ахуйн нэгжээс 3.8 сая төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заасныг зөрчсөн оршин байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс	1	1.8	-	-	1	1.8	1	1.8	-	-	-	-
Дүн	1	1.8	-	-	1	1.8	1	1.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл												
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс	2	3.8	-	-	2	3.8	1	-	-	-	-	-
Дүн	3	3.8	-	-	2	3.8	1	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой								
Шилэн дансанд мэдээллийг дутуу мэдээлсэн	1	-	-	-	1	-	-	-
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Байгууллагын автотээврийн хэрэгсэл нь тод өнгийн дэвсгэр бүхий улсын дугааргүй.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-	1	-
Нийт дүн	2				1		1	

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
	НИЙТ		1			1			